



АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 1111

Улаанбаатар хот

Олон улсын сувилагч, эх баригчдын
өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг, Эрүүл Мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/201 дүгээр тушаал, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүрмийн 5.5, 5.8.6, 5.8.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр тохиох Олон улсын сувилагчдын өдрийг амаржих газрын хэмжээнд “Сувилагчдын бие даасан байдал-Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулъя” уриан дор тэмдэглэхтэй холбогдуулан сувилахуйн алба, тасаг нэгжүүд сувилагч, эх баригчийн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг сайжруулах, сувилагчдын бие даасан байдал, мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, сурталчлах, нийгэмд мэдээлэл хүргэх үйл ажиллагааг зохион байгуулах, хавдраас урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал” сэдэвт аяны удирдамжийг хоёрдугаар, “Багш, шавийн барилдлага” тогтоох үйл ажиллагааны удирдамжийг гуравдугаар, эх баригч, сувилагч тусгай мэргэжилтэн нарыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны удирдамжийг дөрөвдүгээр, шаардагдах төсвийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сувилахуй, эх барихуйн чиглэлээр хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээг төлөвлөн үр дүнтэй зохион байгуулж, Эрүүл Мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлд 2022 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр тайлагнан ажиллахыг Сувилахуйн албаны дарга /Ч.Бурмаа/-д үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах төсвийн тооцоог холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Дангаа/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /С.Ганболд/-д даалгасугай.

ЗАХИРАЛ

Ц.БАТБОЛД

